

“МОНГОЛ ОРНЫ БАРУУН БҮСЭД ГАЗРЫН ДОРОЙТОЛ, ХӨГЖЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ” MON/16/301 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Товч мэдээлэл

Төсөл хэрэгжих хугацаа:

2016-2019

Төсөв:

ДДБОС 1,289,863 ам.доллар

НҮБХХ 850,000 ам.доллар

Засгийн газар 4,430,000

ам.доллар

Төсөл хэрэгжих газар:

Монгол орны баруун бүс

Завхан, Ховд болон Увс аймаг

Хэрэгжүүлэгч:

Байгаль орчин, аялал

жуулчлалын яам

МОНГОЛ ОРНЫ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 77.8% нь цөлжилт, газрын доройтолд өртсөн. Үүнээс 35.3% нь сул, 25.9% нь дунд, 6.7% нь хүчтэй, 9.9% нь нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна. Цөлжилтийн үйл явц нь байгалийн хязгаарлагдмал нөөцийг зохисгүй ашиглахаас үүдэлтэй бөгөөд энэхүү нөхцөл байдал уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр улам даамжрах хандлагатай болдог.



Цөлжилт нэн хүчтэй илэрч буй газрууд

Олон улсын ач холбогдол



ДДБОС-гийн 3 дахь зорилт:

Газар ашиглалтаас байгалийн нөөцөд учруулж буй дарамтыг бууруулах.



НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын 15 дахь зорилт:

Ойн тогтвортой менежмент, цөлжилттэй тэмцэх, газрын доройтол, биологийн олон янз байдлын хомсдлыг зогсоох, нөхөн сэргээх.



Цөлжилттэй тэмцэх Конвенц:

Газрын доройтолгүй болох “Манай дэлхийн газар хөрс нь тогтвортой хөгжил, хүнсний аюулгүй байдал, ядуурлыг бууруулах баталгаа юм.



Биологийн олон янз байдлын конвенцийн Айчигийн зорилтууд:



ГАЗРЫН ДОРОЙТОЛ

Газрын доройтол нь цөлжилтийг эрчимжүүлэх, байгалийн унаган төрхийг сэргээх боломжгүй болтол доройтуулах, биологийн олон янз байдал, экосистемийн бүрэн бүтэн байдалд нөлөөлөхүйц хэмжээнд хүрч байна. Газрын нөөцийн нөхөн сэргээх чадвар, даац, үржил шим буурч байгаа нь цаашид эдийн засгийн гол салбарууд болох хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт төдийгүй тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлнө.

Бэлчээрийн газрыг ашиглах бодлого, зохицуулалт хангалтгүй, хариуцлагагүй уул уурхай болон хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны улмаас газрын доройтол улам бүр нэмэгдсээр байна



ГАЗРЫН
ДОРОЙТОЛ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг эрчимтэй хөгжиж байгаа нь уул уурхайн салбартай шууд холбоотой. 2014 оны байдлаар уул уурхайн хайгуулын болон ашиглалтын 2768 зөвшөөрөл олгогдсон байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 7.5 хувийг хамарч байна. Хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаа нь газар, хөрс, ус, биологийн олон янз байдалд олон эрсдэл дагуулахын зэрэгцээ экосистемийн бүрэн бүтэн байдал, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Үндэсний ач холбогдол

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /2016 он/:

- Цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээг 2030 он гэхэд 10,2%-иар бууруулна /2016 онд 78,2% байна/;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2030 он гэхэд 30 хувьд хүргэнэ /2016 онд 17,4 %/

Ногоон хөгжлийн бодлого /2013 он/:

- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр /2010 он/:

- Цөлжилт, газрын доройтлын аюул нүүрлээд байгаа газарт хөрөнгө оруулалтыг түлхүү чиглүүлэх, доройтлын хэм хэмжээ өндөртэй нутагт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, бодит үр ашиг бий болгох үйл ажиллагааг дэмжин ажиллах зарчимтай.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр /2015 он/:

- Экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах

Оролцогч талууд

Төрийн байгууллага:

- Уул уурхайн яам
- Хүнс, хөдөө аж ахуйн яам
- Сангийн яам
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Орон нутгийн мэргэжлийн хяналтын газрууд
- Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх үндэсний комисс

Судалгаа, шинжилгээний байгууллага:

- Газарзүй-Геоэкологийн хүрээлэн
- Ботаникийн хүрээлэн
- Биологийн хүрээлэн

Олон улсын байгууллага:

- Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлаг
- Азийн сан

Монгол Улсын Их Хурал 2012 онд шинэчилэн баталсан байгаль орчны багц хууль, журамд уул уурхайн нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээхтийн үе шат, биологийн олон янз байдлын /газар хамааралтай/ дүйцүүлэн хамгаалал, хөндлөнгийн үнэлгээг сайжруулах үүднээс байгаль орчны аудит, олон нийтийн оролцоо, стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ зэрэг асуудлыг шинээр нэмж оруулсан.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ҮЕ ШАТ

Уул уурхайн төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах үе шаттайгаар бууруулна. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаа эхлэх үеэс байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх буюу зайлсхийх
- Зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийг багасгах бууруулах
- Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх
- Эцэст нь ноцтой хэмжээний нөлөөлөл үлдэх тохиолдолд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ эсвэл үлдэгдэл нөлөөллийг тэглэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Уул уурхайн төслөөс байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үе шат



ЯМАР ТОХИОЛДОЛД ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?

Уул уурхайн төсөл нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн гүйцэд авсны дараа тухайн газарт **нөхөн сэргэх боломжгүй ноцтой нөлөөлөл зайлшгүй үлдэнэ гэж урьдчилан тооцоолсон тохиолдолд** дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна.

Тухайн бүс нутагт ховор, ховордсон, унаган зүйл ургамал, амьтны зүйлийг хорогдуулсан буюу амьдрах орчныг нь алдагдуулсан, экологийн хувьд чухал ач холбогдолтой, олон улсын гэрээ конвенцийн хүрээнд хамгаалсан газар нутгийг доройтуулсан, хуримтлагдах нөлөөлөлд өртөж болзошгүй тохиолдлууд ноцтой нөлөөлөл гэж үзнэ.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Уул уурхайн төслийн үйл ажиллагааны улмаас биологийн олон янз байдал түүний амьдрах орчинд **ноцтой нөлөөлөл үлдэх тохиолдолд** нөлөөлөлд өртсөн газартай адил байгаль экологийн нөхцөлтэй өөр газарт биологийн олон янз байдлыг хэвийн нөхцлөөс илүүтэй сайжруулах байгаль хамгааллын арга хэмжээг **дүйцүүлэн хамгаалал** гэнэ.

Төрийн бус байгууллага:

- ❑ Монголын байгаль орчны иргэний зөвлөл
- ❑ Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
- ❑ Дэлхийн байгаль хамгаалах сан
- ❑ Даян дэлхийн байгаль орчны сан
- ❑ “Де нэйчэ консерванси”
- ❑ “Ногоон алт”

Хувийн хэвшлийн байгууллага:

- ❑ Уул уурхайн компаниуд
- ❑ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний мэргэжлийн байгууллагууд

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал **хэвийн нөхцлөөс илүү сайжирсан** байх нь эцсийн зорилго юм.



ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫГ НЭВТРҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Дүйцүүлэн хамгаалал нь шинэ ойлголт учраас хэрэгжүүлэхэд үндэсний болон орон нутгийн түвшинд төр захиргааны байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага зэрэг бүх талуудад мэдлэг, чадвар, туршлага дутагдаж байна. Тийм ч учраас 2012 оноос хойш дүйцүүлэн хамгааллыг амжилттай хэрэгжүүлж буй загвар жишээ хомс байна. Дүйцүүлэн хамгаалал хэрэгжихгүй байгаа бас нэг шалтгаан нь дүйцүүлэн хамгааллын үе шат, түүнд тавигдах шаардлага нь тодорхой бус байгаатай холбоотой. Дүйцүүлэн хамгааллын зарчим нь газрын доройтлыг бууруулах арга зам учраас ашигт малтмалын болон газрын асуудлыг зохицуулдаг эрхзүйн баримт бичгүүдэд холбогдох зохицуулалтыг нэмэлтээр тусган хооронд нь уялдуулах шаардлага тулгарч байна.

Холбоо барих хаяг

“Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төсөл

Засгийн газрын II байр, 310 тоот Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Чингэлтэй дүүрэг Улаанбаатар 15160, Монгол улс

Утас: +976 - 770 94432

+976 – 326 595

ТӨСЛИЙН ЗОРИЛТ

Монгол орны баруун бүс нутагт газрын доройтлыг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг газар ашиглалтын төлөвлөлт, менежментэд нэвтрүүлэх замаар уул уурхайгаас бэлчээр, газар нутагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ГАЗАР

Монгол орны баруун бүс дэх Завхан, Ховд, Увс аймаг. Завхан аймгийн Дөрвөлжин сумын Баян-Айраг алтны орд, Ховд аймгийн Дарви сумын Хөшөөт, Увс аймгийн Бөхмөрөн сумын Хотгорын нүүрсний ордуудад төслийн хүрээнд дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлнэ.



ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

Баруун 5 аймгийн

41.5 саяга

нутагт экологийн бүс нутгийн үнэлгээнд тулгуурласан газар ашиглалтын төлөвлөгөө, менежментийг нэвтрүүлнэ



Экологийн бүс нутгийн үнэлгээнд үндэслэн хамгаалалттай газар нутгийн хэмжээг

10%

нэмэгдүүлсэн байна



Уул уурхайн нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагуудын чадавхийн түвшинг

25%

нэмэгдүүлсэн байна.



Уул уурхайн нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг оновчтой нэвтрүүлэх чиглэлээр иргэдийн мэдлэг аймагт

10%

суманд

30%

нэмэгдсэн байна



Нийт

100,000 га газарт

дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлсэн байна



Баян-Айраг алтны орд, Хөшөөт, Хотгорын нүүрсний ордуудын БОМТ-ий нэг жилийн төсөв 2014 оныхтой харьцуулахад

50%

нэмэгдсэн байна.



Увс, аймаг, сумын түвшний газар ашиглалтын төлөвлөгөөнд газрын доройтлыг бууруулах, дүйцүүлэн хамгааллын үе шатыг хуулийн нэмэлт өөрчлөлтөөр баталгаажуулан эрх зүйн орчинг сайжруулсан байна.

МАН, газар тариалан эрхэлдэг 250 өрх газрын тогтвортой менежментийг нэвтрүүлэх, газрын доройтлыг бууруулах инновацийг нэвтрүүлэн, доройтсон газар нутгийн

30%

сэргээсэн байна.

